

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-12-ЫН ХАРЬЦУУЛАЛТ

<p align="center">Осол, зөрчил болон статистик мэдээлэл</p> <p align="center"><i>(Шинэчлэгдэж байгаа)</i> <i>/18 хуудас/ 2017 оны NZ amend.10</i></p>	<p align="center">ОСОЛ, ЗӨРЧЛИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭХ</p> <p align="center"><i>(Хүчинтэй мөрдөгдөж байгаа)</i> <i>/13 хуудас (үндсэн дүрэм-39 хуудастай байсан)/ 2001 оны NZ amend.1</i></p>	<p align="center">Тайлбар</p>
<p>А Бүлэг Ерөнхий зүйл</p>	<p>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</p>	
<p>12.1. Зорилго</p> <p>(а) Энэ зүйлийн (b)-г харгалзан, энэ Дүрэм нь дараах шаардлагыг тогтооно:</p> <p>(1) осол, зөрчлийн талаар мэдээлэх, шинжлэн шалгах, ба тайлан гаргах;</p> <p>(2) осол, эсхүл ноцтой зөрчлийн дараа агаарын хөлөг, агаарын хөлөгт агуулагдсан эд зүйл болон агаарын хөлгийн бүртгэлийг хамгаалалтад авах;</p> <p>(3) осол, байгууламжийн доголдлын зөрчил, агаарын зайн зөрчил, эсхүл түгээгдсэн мэдээллийн зөрчилтэй холбоотой бүртгэлийг хамгаалалтад авах;</p> <p>(4) агаарын хөлгийн үйл ажиллагаа, статистик тоо баримтын тайлан гаргах.</p> <p>(б) Энэ Дүрэм нь, Хууль болон ИНД-115-ын дагуу Даргын олгосон Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнээс гадуур хийгддэг дараах үйл ажиллагаатай холбоотой зөрчилд хамаарахгүй:</p> <p>(1) ИНД-101, ИНД-102-ын дагуу гүйцэтгэж байгаа жиро-глайдер, парасэйл, хүнгүй агаарын хөлөг, цаасан шувуу болон пуужингийн үйл ажиллагаа;</p> <p>(2) ИНД-103-ын дагуу гүйцэтгэж байгаа хэт хөнгөн агаарын хөлгийн үйл ажиллагаа;</p> <p>(3) ИНД-104-ийн дагуу гүйцэтгэж байгаа глайдерын үйл ажиллагаа;</p> <p>(4) ИНД-105-ын дагуу гүйцэтгэж байгаа шүхрийн үйл ажиллагаа;</p> <p>(5) ИНД-106 -гийн дагуу гүйцэтгэж байгаа ханг-глайдерын үйл ажиллагаа.</p>	<p>12.1. Зорилго</p> <p>(а) Энэ дүрмээр иргэний агаарын хөлгийн осол, ноцтой зөрчил болон иргэний нисэхийн аюулгүй ажиллагаатай холбоотой аливаа бусад хэрэг явдлын талаар мэдээлэл хүлээн авах, мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг зохицуулна.</p> <p><u>(б) Осол, зөрчлийн талаар мэдээлэл хүлээн авах, цуглуулах үйл ажиллагааны гол зорилго нь хэн нэгнийг буруутгах, эсхүл хариуцлага хүлээлгэхэд бус, осол, зөрчил давтан гарахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ авахад оршино.</u></p> <p>12.3. Үйлчлэх хүрээ</p> <p>(а) Энэ дүрэм нь энэ зүйлийн (б)-д зааснаас бусад, иргэний нисэхийн бүх үйл ажиллагаанд хамаарна.</p> <p>(б) Энэ дүрэм нь ИНД-101, ИНД-103, ИНД-104, ИНД-105 болон ИНД-106-ийн дагуу явуулж буй үйл ажиллагаанд хамаарахгүй.</p>	<p>-2008 онд Amend.4-өөр (а)(2), (3),(4)-р заалт нэмэгдсэн</p> <p>- мэдээлэх шаардлагатай үйл ажиллагаанд ИНД-115-ын дагуух ү/а нэмэгдсэн</p> <p>- мэдээлэх шаардлагагүй үйл ажиллагаанд ИНД-102-ын үйл ажиллагаа нэмэгдсэн</p>
<p>12.3. Нэр томъёо ба товчлол</p> <p>Энэ Дүрэмтэй холбоотой нэр томъёо болон товчлол нь ИНД-ийн нэр томъёоны тайлбарт багтсан.</p>		<p>- Нэр томъёоны тайлбар, тодорхойлолтууд ИНД-1-д орсон.</p>

В Бүлэг - Хэрэг явдлыг мэдээлэх, шинжлэн шалгах ба тайлан гаргах	Б БҮЛЭГ. ОСОЛ, ЗӨРЧЛИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭХ	
<p>12.51. Ослыг мэдээлэх</p> <p>(а) Осолд өртсөн <u>агаарын хөлгийн дарга</u>, эсхүл хэрэв агаарын хөлгийн дарга амь насаа алдсан, эсхүл хүнд гэмтсэн, эсхүл агаарын хөлөг алга болсон тохиолдолд, тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь ослын талаар АХОШШБ болон ИНЕГ-т цаг алдалгүй мэдээлнэ.</p> <p>(б) Энэ зүйлийн (а)-ийн дагуу ирүүлэх мэдээлэл нь ИНЕГ-ын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр байх ба боломжтой бол, дараах мэдээллийг агуулсан байна:</p> <ol style="list-style-type: none"> (1) осол болсон өдөр, цаг; (2) ослын шинж байдал; (3) агаарын хөлгийн маяг, үндэсний харъяалал болон бүртгэлийн дугаар; (4) агаарын хөлгийн өмчлөгч болон үйл ажиллагаа эрхлэгчийн нэр; (5) хялбар тодорхойлогдох газарзүйн цэгээр илэрхийлсэн агаарын хөлгийн байршил, эсхүл хамгийн сүүлд мэдэгдэж байсан байршлын мэдээлэл; (6) агаарын хөлгийн даргын нэр; (7) үйл ажиллагааны төрөл; (8) агаарын хөлгийн нисэн гарсан сүүлчийн цэг; (9) агаарын хөлөг буулт үйлдэхээр төлөвлөсөн дараагийн цэг; (10) тэнгэрийн байдал, хур тунадас, салхины хурд болон алсын барааны харагдцын тодорхойлолт; (11) агаарын хөлгийн бүхээгт байсан хүний тоо; (12) ослын улмаас амь насаа алдсан, эсхүл хүндээр гэмтсэн зорчигч болон багийн гишүүний тоо; (13) ослын улмаас амь насаа алдсан, эсхүл хүндээр гэмтсэн, зорчигч, эсхүл багийн гишүүнээс бусад хүмүүсийн тоо; (14) агаарын хөлгийн гэмтлийн дэлгэрэнгүй мэдээлэл. 	<p>12.51. Осол, ноцтой зөрчлийн тухай заавал мэдээлэх</p> <p>(а) Дараах этгээд нь агаарын хөлгийн осол болон энэ дүрмийн Хавсралт Б-д заасан ноцтой зөрчлийн талаар Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид ИНЕГ гэх/ болон Осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага /цаашид ОЗШШБ гэх/-д нэн даруй мэдээлнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1/ агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч; 2/ агаарын хөлөгт засвар үйлчилгээ, өөрчлөлт сайжруулалт хийдэг, эсхүл агаарын хөлгийн тоног төхөөрөмж, тэдгээрийн хэсгийг үйлдвэрлэдэг байгууллагын гэрчилгээ эзэмшигч; 3/ нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч; 4/ аэродромын гэрчилгээ эзэмшигч; 5/ нисэх буудлын ажилтан; 6/ агаарын навигацгийн техник хангалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч. 	<p>-Ослын талаар заавал мэдээлэх үүрэгтэй гол этгээд болох <u>агаарын хөлгийн даргыг</u> орхигдуулсныг нөхөж оруулсан.</p>
<p>12.53. Ослын дэлгэрэнгүй мэдээлэл</p> <p>(а) Осолд өртсөн <u>агаарын хөлгийн дарга</u>, эсхүл хэрэв агаарын хөлгийн дарга амь насаа алдсан, эсхүл хүнд гэмтсэн тохиолдолд, үйл ажиллагаа эрхлэгч нь СА005 маягтад шаардсан ослын дэлгэрэнгүй мэдээллийг осол гарснаас хойш 10 хоногийн дотор АХОШШБ болон ИНЕГ-т дараах хэлбэрээр хүргүүлнэ:</p> <ol style="list-style-type: none"> (1) СА005 маягтаар; эсхүл 	<p>12.53. Осол, ноцтой зөрчлийн тухай нарийвчилсан мэдээлэл</p> <p>(а) Ослын үед аливаа этгээд амь насаа алдсан буюу хүнд гэмтэл авсан, эсхүл агаарын хөлөг сураггүй алга болсон, эсхүл энэ дүрмийн Хавсралт Б-д заасан ноцтой зөрчил гарсан тохиолдолд энэ дүрмийн 12.51-ийн (а)-д заасан гэрчилгээ эзэмшигч нар нь осол, ноцтой зөрчлийн тухай нарийвчилсан мэдээллийг осол, ноцтой зөрчил гарснаас хойш 7 хоногийн дотор ИНЕГ-012/01 маягтын дагуу гаргаж <u>ИНЕГ</u>-ын даргад</p>	<p>-Ослын дэлгэрэнгүй мэдээллийг осолд өртсөн <u>агаарын хөлгийн дарга</u> өгөх шаардлагыг нөхөж оруулсан.</p>

(2)ИНЕГ-ын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр.

(b)Энэ зүйлийн (а)-д шаардсан дэлгэрэнгүй мэдээлэл нь осол гарсан цаг үед агаарын хөлөгт байсан нисэх багийн гишүүн бүрийн тухайн осолтой холбоотой бодит байдал, нөхцөл болон нөхцөл байдлыг дэлгэрэнгүй дурдсан тайлбарыг агуулна.

(c)Хэрэв нисэх багийн гишүүн эрүүл мэндийн шалтгаанаар энэ зүйлийн (b)-д шаардсан тайлбарыг гаргаж өгөх боломжгүй бол, боломжтой болсон даруйд нөхөн гаргаж өгнө.

12.55. Зөрчлийг мэдээлэх

(a)Хууль болон дараах Дүрмийн дагуу **Даргаас** олгосон гэрчилгээ эзэмшигч нь, хэрэв агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдалд шууд аюул учруулах зөрчил, эсхүл ноцтой зөрчилд өртсөн бол, холбогдох зөрчлийг ИНЕГ-т цаг алдалгүй мэдээлэх үүрэгтэй:

(1)**ИНД-115**, 119, 129 болон **137** - агаарын хөлгийн зөрчил, эсхүл аюултай **барааны** зөрчлийг;

(2)ИНД-172-Агаарын зайн зөрчлийг;

(3)ИНД-171, **174** - **байгууламжийн доголдлын зөрчлийг;**

(4)ИНД-47, **115, 119, 129, 137, 145, 146** болон 148 - гэмтлийн зөрчлийг;

(5)**ИНД-119, 129, 139, 140, 171 болон 172** - аюулгүйн хамгаалалтын зөрчлийг;

(6)ИНД-139 - аэродромын зөрчлийг;

(7)**ИНД-139, 171, 173, 174** болон 175 - түгээгдсэн мэдээллийн зөрчлийг;

(8)**ИНД-119, 129 болон 109** - **ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчлийг.**

(b)Агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдалд шууд аюул учруулах зөрчил, эсхүл ноцтой зөрчилд өртсөн этгээд нь зөрчлийн талаар ИНЕГ-т цаг алдалгүй мэдээлэх үүрэгтэй, хэрэв тухайн этгээд нь:

(1)агаарын хөлөг, нисэхийн бүтээгдэхүүн, эсхүл нисэхтэй холбоотой үйлчилгээний хувьд, үйл ажиллагаа эрхэлдэг, техник үйлчилгээ хийдэг, үйлчилгээ үзүүлдэг, эсхүл бусад

ирүүлнэ.

(б) Осолд өртсөн агаарын хөлгийн нисэх багийн гишүүн бүр нь болсон явдлын талаарх тодорхойлолтыг энэ зүйлийн (а)-д заасан маягтад хавсаргана.

(в) Хэрэв нисэх багийн гишүүний биеийн эрүүл мэндийн хувьд энэ зүйлийн (б)-д заасан тодорхойлолтыг гаргаж өгөх боломжгүй тохиолдолд тодорхойлолтыг нөхөн гаргуулж авна.

12.55. Зөрчлийн талаар заавал мэдээлэх

(a) Энэ дүрмийн Хавсралт А-д заасан зөрчлийн талаар дараах Гэрчилгээ эзэмшигч нар **ИНЕГ** болон ОЗШШБ-д нэн даруй мэдээлнэ. Үүнд:

1/ ИНД-119, ИНД-129-ийн дагуу гэрчилгээ эзэмшигч нь агаарын зайн зөрчил, агаарын хөлгийн ашиглалт, аюултай **ачаа**, агаарын хөлгийн дутагдал, нисэхийн аюулгүй байдал, шувуутай холбоотой зөрчлийн талаар;

2/ ИНД-172-ийн дагуу гэрчилгээ эзэмшигч нь агаарын зайн зөрчил, нислэгийн хөдөлгөөний удирдлагаас шалтгаалсан зөрчлийн талаар;

3/ ИНД-145 болон ИНД-148-ийн дагуу гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлгийн дутагдалтай холбоотой зөрчлийн талаар;

4/ ИНД-139-ийн дагуу гэрчилгээ эзэмшигч нь аэродром дээрх болон шувуутай холбоотой зөрчлийн талаар;

5/ ИНД-171-ийн дагуу гэрчилгээ эзэмшигч нь холбоо, навигацийн тоног төхөөрөмжөөс шалтгаалсан зөрчлийн талаар;

6/ ИНД-140-ийн дагуу гэрчилгээ эзэмшигч нь нисэхийн аюулгүй байдалтай холбоотой зөрчлийн талаар;

7/ ИНД-175-ын дагуу гэрчилгээ эзэмшигч нь мэдээлэлтэй холбоотой зөрчлийн талаар.

(б) Нислэгийн хөдөлгөөний удирдлагаас шалтгаалсан зөрчил, агаарын зайн зөрчил болон шувуунаас шалтгаалсан зөрчилд өртсөн агаарын хөлгийн дарга уг зөрчлийн талаар ОЗШШБ болон **ИНЕГ**-т нэн даруй мэдэгдэнэ.

-Зөрчлийг мэдээлэх үүрэгтэй байгууллага нэмэгдсэн:

- ИНД-115, 137-гийн гэрчилгээ эзэмшигч агаарын хөлгийн зөрчил, эсхүл аюултай барааны зөрчлийг,
- ИНД-174-ийн гэрчилгээ эзэмшигч байгууламжийн доголдлын зөрчлийг,
- ИНД-47, 115, 119, 129, 137, 146-гийн байгууллага гэмтлийн зөрчлийг,
- ИНД-119, 129, 139, 171 болон 172-ын байгууллага аюулгүйн хамгаалалтын зөрчлийг,
- ИНД-139, 171, 173, 174 -ийн байгууллага түгээгдсэн мэдээллийн зөрчлийг,

хэлбэрээр оролцдог бол;

(2) энэ зүйлийн (а)-д дурдсан гэрчилгээ эзэмшигчийн ажилтан биш, эсхүл түүнд хамааралгүй бол; эсхүл

(3) ИНД-95-ын дагуу үүрэг хариуцлага хүлээсэн бол.

(с) Хэрэв агаарын зайн зөрчил, эсхүл шувуутай холбоотой зөрчил нь ноцтой зөрчил, эсхүл агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдалд шууд аюул учруулах зөрчил бол, агаарын хөлгийн дарга зөрчлийн талаар ИНЕГ-т цаг алдалгүй мэдээлэх үүрэгтэй.

(d) Энэ зүйлийн (а), (b), (с) болон (d)-д шаардсан зөрчлийн мэдээллийг ИНЕГ-ын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр ирүүлэх үүрэгтэй ба тодруулах боломжтой бол дараах хавсралтад заасан мэдээллийг агуулсан байна:

(1) агаарын зайн зөрчлийн хувьд, Хавсралт А(a);

(2) гэмтлийн зөрчлийн хувьд, Хавсралт А(b);

(3) байгууламжийн доголдлын зөрчлийн хувьд, Хавсралт А(c);

(4) агаарын хөлгийн зөрчлийн хувьд, Хавсралт А(d);

(5) аюулгүйн хамгаалалтын зөрчлийн хувьд, Хавсралт А(e);

(6) түгээгдсэн мэдээллийн зөрчлийн хувьд, Хавсралт А(f);

(7) аэродромын зөрчлийн хувьд, Хавсралт А(g);

(8) ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчлийн хувьд, Хавсралт А(h);

(9) аюултай барааны зөрчил, шувуутай холбоотой зөрчил, эсхүл бусад зөрчлийн хувьд, Хавсралт А(i).

(e) Энэ зүйлийн (а)-г үл харгалзан:

(1) Хууль болон ИНД-119-ийн дагуу Даргын олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч, хэрэв зөрчил нь EDTO нислэгт ашиглаж байгаа, эсхүл ашигладаг агаарын хөлөгтэй холбоотой гарсан ба тухайн зөрчилд дараах нөхцөл байдал холбоотой бол, зөрчил гарснаас хойш 72 цагийн дотор зөрчлийн талаар ИНЕГ-т мэдээлэх үүрэгтэй:

(i) татах хүчний төхөөрөмж агаарт унтрах; эсхүл

(ii) даялалт (diversion), эсхүл буцах эргэлт (a turn back) үйлдэх үед; эсхүл

(iii) нислэгт гэнэт түлш алдагдах, эсхүл түлшгүй болох, эсхүл залруулах боломжгүйгээр түлшний тэнцвэр алдагдах; эсхүл

(iv) EDTO нислэгт нөлөөлөх системийн доголдол; эсхүл

(v) EDTO нислэгийн аюулгүй байдалд нөлөөлөх бусад хэрэг явдал;

(2) хэрэв EDTO нислэгт ашигладаг агаарын хөлөгтэй холбоотой дараах зөрчил гарсан бол, Хууль болон ИНД-145-ын дагуу олгосон техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь гэмтлийн зөрчлийг 72 цагийн дотор ИНЕГ-т

(в) Энэ зүйлийн (а)-д заасан зөрчлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг гэрчилгээ эзэмшигч нь зөрчил гарснаас хойш 10 хоногийн дотор ИНЕГ-12/02 маягтын дагуу гаргаж ИНЕГ-т ирүүлнэ.

-2008 онд Amend.7-оор (1), (2),(3)-р заалт нэмэгдсэн

-2008 онд Amend.7-оор(1),(2),(3)(4),(5),(6),(7),(8),(9)-р заалт нэмэгдсэн

- EDTO нислэгийн холбогдолтой

<p>мэдээлэх үүрэгтэй:</p> <p>(i) EDTO нислэгт нөлөөлөх системийн доголдолтой холбоотой зөрчил; эсхүл</p> <p>(ii) EDTO нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн аюулгүй байдалд нөлөөлөх бусад гэмтэл.</p>		<p>зөрчлийг мэдээлэх шаардлага нэмэгдсэн</p>
<p>12.57. Зөрчлийн дэлгэрэнгүй мэдээлэл</p> <p>(a) Агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдалд шууд аюул учруулах зөрчил, эсхүл ноцтой зөрчлийн талаар 12.55-д заасны дагуу мэдээлснийг үл харгалзан, зөрчилтэй холбоотой дараах этгээд нь зөрчлийн дэлгэрэнгүй мэдээллийг (b)(1), эсхүл (b)(2)-т заасан холбогдох маягтад шаардсаны дагуу ИНЕГ-т хүргүүлэх үүрэгтэй:</p> <p>(1) 12.55 (a)-д дурдсан гэрчилгээ эзэмшигч;</p> <p>(2) 12.55 (b)-д дурдсан этгээд;</p> <p>(3) 12.55 (c)-д дурдсан хөлгийн дарга.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан этгээд нь зөрчлийн дэлгэрэнгүй мэдээллийг тухайн зөрчил гарснаас хойш 14 хоногийн дотор ИНЕГ-т дараах хэлбэрээр хүргүүлэх үүрэгтэй:</p> <p>(1) CA005 маягтаар; эсхүл</p> <p>(2) гэмтлийн зөрчлийг CA005D маягтаар; эсхүл</p> <p>(3) ИНЕГ-ын хүлээн зөвшөөрөхүйц бусад хэлбэрээр.</p>		<p>-Орхигдуулсан зүйлийг нөхөж оруулсан</p>
	<p><u>12.57. Осол, зөрчлийн талаар сайн дураар мэдээлэх</u></p> <p>(a) Энэ дүрмийн дагуу осол, зөрчлийн талаар заавал мэдээлэх үүрэг хүлээгээгүй боловч агаарын хөлөг ашигладаг, түүнд засвар, үйлчилгээ хийдэг болон иргэний нисэхийн бусад үйл ажиллагаанд оролцогч болон аливаа бусад этгээд нь осол, зөрчлийн талаар, эсхүл иргэний нисэхийн аюулгүй ажиллагаанд бий болсон бодит аюул, эрсдлийн талаар <u>ИНЕГ</u>-т, эсхүл ОЗШШБ-д мэдээлж болно.</p> <p>(б) Энэ зүйлийн (a)-д заасны дагуу мэдээлэл хүлээн авсан эрх бүхий байгууллагууд нь ирүүлсэн мэдээллийг зөвхөн аюулгүй ажиллагааг дээшлүүлэх зорилгод ашиглана гэдгийг бататгах үүднээс тухайн мэдээлэгчийн, эсхүл гуравдагч этгээдийн хувийн байдлыг тогтооход ашиглаж болзошгүй зүйлүүдийг мэдээллээс хасна.</p> <p>(в) Иргэний нисэхийн үнэмлэх эзэмшигч хувь хүн, гэрчилгээ эзэмшигч байгууллага нь иргэний нисэхийн хууль, дүрмийг санамсар болгоомжгүй аль нэг байдлаар зөрчсөн зөрчлийнхөө талаар ОЗШШБ, эсхүл ИНЕГ-т сайн дураараа мэдээлсэн тохиолдолд мэдээлэл хүлээн авсан эрх бүхий байгууллага нь ирүүлсэн мэдээллийг ямар ч тохиолдолд мэдээлэгчийн эсрэг ашиглахыг хориглоно.</p>	<p>-Annex 13-ын шаардлага, хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан</p>
<p>12.59. Шинжлэн шалгах ажиллагаа болон тайлан</p>		<p>-Орхигдуулсан</p>

<p>Энэ дүрмийн 12.57-д заасны дагуу ИНЕГ-т зөрчлийн дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлэх шаардлагатай 12.55(а)-д дурдсан <u>гэрчилгээ эзэмшигч нь, ИНЕГ-аас өөрөөр мэдэгдсэнээс бусад тохиолдолд дараах үүрэгтэй:</u></p> <p>(1) тухайн зөрчилтэй холбоотой бодит байдлыг тодорхойлох, бодит байдлын хүрээнд зөрчлийн шалтгаан, эсхүл шалтгаануудыг тогтоох; зорилгоор шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэх;</p> <p>(2) тухайн зөрчил гарснаас хойш 90 хоногийн дотор шинжлэн шалгах ажиллагааг дуусган, тайланг ИНЕГ-т дараах хэлбэрээр хүргүүлэх:</p> <p>(i) СА005 маягтаар; эсхүл</p> <p>(ii) гэмтлийн зөрчлийг СА005D маягтаар; эсхүл</p> <p>(iii) ИНЕГ-ын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр;</p> <p>(3) ижил төстэй зөрчил давтагдахаас сэргийлэх зорилгоор, авсан арга хэмжээний талаар ИНЕГ-т мэдээлэх.</p>	<p><u>12.101. Зөрчлийг шинжлэн шалгах ба тайлагнах</u> <u>(а) Энэ дүрмийн Хавсралт А-д заасан зөрчлийг ИНЕГ-ын эрх бүхий этгээд зөрчил гарснаас хойш 90 хоногийн дотор шинжлэн шалгаж, тайланг ОЗШШБ-д хүргүүлнэ.</u></p>	<p>заалтыг нөхөж оруулсан</p> <p><u>-Энэ заалтыг орхигдуулснаас болоод Үйл ажиллагаа эрхлэгчид шинжлэн шалгах ажиллагаа хийдэггүй байсан.</u></p>
<p>12.61. Мэдээлэл өгсөн этгээдийг нууцлах Энэ дүрмийн 12.55, эсхүл 12.57-д заасны дагуу мэдээлэл өгсөн этгээд нь нууцлахыг хүссэн тохиолдолд, АХОШШБ болон ИНЕГ нь:</p> <p>(1) эх үүсвэрийг таньж тогтоож болох мэдээллийг цаг алдалгүй арилгана;</p> <p>(2) энэ зүйлийн (1)-ийн дагуу арилгасан мэдээллийг өөр аль ч бүртгэлд тэмдэглэхгүй.</p>	<p><u>12.103. Мэдээллийн нууцыг хамгаалах</u> (а) ИНЕГ болон ОЗШШБ нь энэ дүрмийн дагуу хүлээн авсан аливаа мэдээллийг нууцлах журмыг тогтоосон байх ба ирүүлсэн мэдээллийг зөвхөн энэ дүрмийн 12.1-ийн (б)-д заасан зорилгоор ашиглана.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>12.63. Шийтгэлээс ангид байх АХОШШБ болон ИНЕГ нь дараахаас бусад тохиолдолд, аливаа этгээдийн энэ дүрмийн дагуу өгсөн мэдээллийг мөрдөн шалгах, эсхүл хариуцлага тооцох зорилгоор ашиглахгүй, эсхүл ашиглах боломж олгохгүй:</p> <p>(1) тухайн мэдээлэл нь хүн, эсхүл өмч хөрөнгөд хэрэгцээ шаардлагагүйгээр аюул учруулсан үйлдэл, эсхүл эс үйлдлийг илчилсэн бол; эсхүл</p> <p>(2) хуурамч мэдээлэл өгсөн бол; эсхүл</p> <p>(3) АХОШШБ болон ИНЕГ нь мэдээллийг хуулийн дагуу, эсхүл шүүхийн шийдвэрийн дагуу гаргаж өгөх үүрэг хүлээсэн бол.</p>		<p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p>
<p>С Бүлэг-Агаарын хөлөг, түүний эд зүйл бүртгэлийг хамгаалах</p>	<p>В БҮЛЭГ. БУСАД ЗҮЙЛ</p>	
<p>12.101. Осолд өртсөн агаарын хөлөгт нэвтрэх (а) Хууль болон энэ зүйлийн (b), (c)-д зааснаас бусад тохиолдолд, АХОШШБ-аас тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрөөгүй бол, аливаа этгээд нь осолд өртсөн агаарын хөлөг, эсхүл түүнд агуулагдсан эд зүйлд нэвтрэх, оролдох, эсхүл салгаж авч болохгүй.</p> <p>(b) Хуульд заасан хязгаарлалтыг харгалзан, АХОШШБ нь шинжлэн шалгах зорилгоор, осолд өртсөн агаарын хөлөг,</p>		

<p>эсхүл түүнд агуулагдсан эд зүйлд нэвтрэх, үзлэг шалгалт хийх, хамгаалах, эсхүл салгаж авч болно.</p> <p>(с) Энэ зүйлийн (d)-г харгалзан, этгээд нь:</p> <p>(1) хүмүүс, эсхүл мал амьтныг тухайн агаарын хөлөг, эсхүл эвдэрхий хэсгийн дотроос гаргана; эсхүл</p> <p>(2) агаарын хөлөг, эвдэрхий хэсэг, эсхүл түүнд агуулагдсан ачаа, эсхүл шууданг цаашдын гэмтлээс хамгаална; эсхүл</p> <p>(3) бүхээгийн яриа бичигч (CVR), нислэгийн өгөгдөл бичигч (FDR), эсхүл ослын байрлал дамжуулагчийг унтраах, эсхүл салгана; эсхүл</p> <p>(4) боломжит өөр арга зам байхгүй тохиолдолд олон нийтэд, эсхүл нислэгийн хөдөлгөөнд саад учруулахаас сэргийлнэ.</p> <p>(d) Энэ зүйлийн (с)-д заасны дагуу салгаж авсан агаарын хөлгийн эвдэрхий хэсэг, шуудан, эсхүл ачааг:</p> <p>(1) зөвхөн тэдгээрийн аюулгүй байдлыг бататгах шаардлагатай зайд шилжүүлнэ;</p> <p>(2) тухайн агаарын хөлгийн аль хэсгээс авсныг үзүүлэх боломжтойгоор тусдаа талбайд хадгална;</p> <p>(3) боломжтой бол тэдгээрийн анхны байрлал, мөргөлтийн чухал ул мөрийг гэрэл зураг, гар зураг, эсхүл тэмдэглэлээр баримтжуулна.</p>		<p>-Орхигдуулсан Бүлгийг нэмж оруулсан</p>
<p>12.103. Бүртгэлийг хамгаалалтад авах</p> <p>(a) Ноцтой зөрчил, эсхүл осолд өртсөн агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаа болон техник үйлчилгээтэй холбоотой бүх мэдээллийг агуулсан бичлэгийн төхөөрөмжийг багтаасан бүртгэлийг АХОШШБ болон ИНЕГ-аас өөрөөр мэдэгдээгүй бол осол, эсхүл ноцтой зөрчил гарснаас хойш 14 хоногоос доошгүй хугацаагаар битүүмжлэн хадгалах үүрэгтэй.</p> <p>(b) Зөрчил, эсхүл осолд холбогдсон, дараах Дүрмийн дагуу олгосон гэрчилгээ эзэмшигч нь: , АХОШШБ болон ИНЕГ-аас өөрөөр мэдэгдээгүй бол осол, эсхүл зөрчилтэй холбоотой бүртгэлийн дэвтэрт оруулсан бичилт, цахим бичлэг, техникийн болон холбогдох бусад өгөгдлийг багтаасан бүх бүртгэлийг тухайн осол, эсхүл зөрчил болсноос хойш 14 хоногоос доошгүй хугацаагаар битүүмжлэн хадгалах үүрэгтэй.</p> <p>(1) ИНД-171-байгууламжийн доголдлын зөрчил, эсхүл осол; эсхүл</p> <p>(2) ИНД-172- агаарын зайн зөрчил, эсхүл осол; эсхүл</p> <p>(3) ИНД-173, ИНД-175 - түгээгдсэн мэдээллийн зөрчил, эсхүл осол;</p> <p>(с) Түгээгдсэн мэдээллийн осол, эсхүл зөрчилд холбоотой, ИНД-95-ын дагуу үүрэг хариуцлага хүлээсэн этгээд нь бүртгэлд оруулсан бичилт, цахим бичлэг, техникийн болон бусад</p>		<p>-Орхигдуулсан зүйлийг нэмж оруулсан.</p>

<p>холбогдох өгөгдлийг багтаасан бүх бүртгэлийг АХОШШБ болон ИНЕГ-аас өөрөөр мэдэгдээгүй бол, тухайн осол, эсхүл зөрчил болсноос хойш 14 хоногоос доошгүй хугацаагаар битүүмжлэн хадгалах үүрэгтэй.</p>		
<p>12.105. Гэмтэлтэй бүтээгдэхүүн, бүрдэл хэсгийг хадгалах Агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч болон 12.59(2)-ын дагуу гэмтлийн зөрчлийн талаар АХОШШБ болон ИНЕГ-т мэдээлэх үүрэг хүлээсэн ИНД-145, ИНД-146, эсхүл ИНД-148-ын дагуу гэрчилгээ эзэмшигч нь гэмтлийн зөрчилтэй холбоотой бүтээгдэхүүн, эсхүл бүрдэл хэсгийг АХОШШБ болон ИНЕГ-аас өөрөөр мэдэгдээгүй бол, тухайн мэдээлэл өгснөөс хойш 14 хоногоос доошгүй хугацаагаар битүүмжлэн хадгалах үүрэгтэй.</p>		<p>-Орхигдуулсан заалтыг оруулсан</p>
	<p><u>12.105. Осол, зөрчлийн мэдээллийн сан</u> <u>(а) ИНЕГ нь осол, зөрчлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх болон урьдчилан сэргийлэх аливаа арга хэмжээг тодорхойлох зорилго бүхий осол зөрчлийн мэдээллийн сантай байна.</u> <u>(б) Мэдээлэл солилцох үйл ажиллагааг хялбарчлах зорилгоор мэдээллийн сангийн системд Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын стандарт загварыг ашиглана.</u> <u>(в) ИНЕГ нь иргэний нисэхийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудтай аюулгүй ажиллагааны мэдээллийг тогтмол солилцоно.</u></p>	<p>-Үндэслэлгүйгээр нэмж оруулсан.</p>
	<p><u>12.107. Осол, зөрчлийн мэдээллийн систем</u> <u>(а) Иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагууд нь осол, зөрчлийн мэдээллийг хүлээн авах, тайлагнах системийг тогтоосон байна.</u></p>	<p>-Үндэслэлгүйгээр нэмж оруулсан.</p>
	<p><u>12.109. Гадаадын агаарын хөлгийн эвдрэл гэмтлийн талаар мэдэгдэх</u> <u>(а) ИНЕГ нь, Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын агаарын хөлөгт тохиолдсон эвдрэл гэмтлийн талаар тухайн агаарын хөлгийг Бүртгэгч улсад нэн даруй мэдэгдэнэ.</u></p>	<p>-Үндэслэлгүйгээр нэмж оруулсан.</p>
	<p><u>12.111. Хариуцлага</u> <u>(а) Иргэний нисэхийн үйл ажиллагаанд гарсан аливаа осол, зөрчлийг мэдээлээгүй нүүн дарагдуулсан, худал мэдээлсэн хувь хүн, эсхүл аж ахуйн нэгж, байгууллагад Иргэний нисэхийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.</u></p>	<p>-Үндэслэлгүйгээр нэмж оруулсан.</p>
<p><u>D Бүлэг-Статистикийн мэдээлэл</u></p>		
<p>12.151. Агаарын хөлгийн үйл ажиллагааны статистикийн мэдээлэл (а) Хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаа эрхлээгүй глайдераас бусад, агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь Хүснэгт 1-д заасан статистикийн тоо баримт болон мэдээллийг</p>		<p>-Орхигдуулсан бүлгийг нөхөж оруулсан.</p>

агаарын хөлөг тус бүрээр, хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагааны тайланг Хүснэгт 2-т заасан хамрах болон эцсийн хугацаанд, хөлс, эсхүл шан урамшуулалгүй үйл ажиллагааны тайланг Хүснэгт 3-т заасан хугацаанд хүргүүлэх үүрэгтэй.

(b)Энэ зүйлийн (a)-д шаардсан мэдээллийг дараах байдлаар хүргүүлэх үүрэгтэй:

(1)CAA605 маягтаар; эсхүл

(2)цахим, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц бусад хэлбэрээр.

(c)Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь, Хүснэгт 2, эсхүл Хүснэгт 3-т заасан хугацаанд тухайн агаарын хөлөг нислэг үйлдсэн эсэхээс үл хамааран агаарын хөлгийн үйл ажиллагааны статистикийн мэдээллийг үргэлжлүүлэн өгөх үүрэгтэй.

Хүснэгт 1. Агаарын хөлгийн үйл ажиллагааны төрөл тус бүрээр гаргах шаардлагатай статистикийн тоо баримт, мэдээлэл

Агаарын хөлгийн үйл ажиллагаа	Статистикийн тоо баримт, мэдээлэл
Гадаад улс руу, гадаад улсаас болон гадаад улсад арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашигладаг Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг	<ul style="list-style-type: none"> • Агаарын хөлгийн бүртгэлийн дугаар • Ниссэн цаг • Зорчигч тээвэрлэсэн нислэгийн тоо • Зөвхөн ачаа тээвэрлэсэн нислэгийн тоо • Зөвхөн ачаа тээврийн нислэгээр тээвэрлэсэн ачааны нийт жин, тонноор
Орон нутгийн арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашигладаг Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг	<ul style="list-style-type: none"> • Агаарын хөлгийн бүртгэлийн дугаар • Ниссэн цаг • Хоёр өөр аэродромын хооронд зорчигч тээвэрлэсэн нислэгийн тоо • Завсрын буултгүйгээр, нэг аэродромоос эхэлж тухайн аэродромдоо дууссан, зорчигч тээвэрлэсэн нислэгийн тоо • Зөвхөн ачаа тээвэрлэсэн нислэгийн тоо • Зөвхөн ачаа тээврийн нислэгээр тээвэрлэсэн ачааны нийт жин, тонноор

-ИНД-321
“Статистикийн мэдээлэл” – FAA эх үүсвэртэй дүрэм тусдаа гаргасан

Монгол Улсаас болон Монгол Улс дотор зөвхөн ачааны арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашигладаг Монгол Улсын бүртгэлгүй агаарын хөлөг	<ul style="list-style-type: none"> • Агаарын хөлгийн бүртгэлийн дугаар • Зөвхөн ачаа тээвэрлэсэн нислэгийн тоо • Зөвхөн ачаа тээврийн нислэгээр тээвэрлэсэн ачааны нийт жин, тонноор
Шүхрийн үйл ажиллагаанаас бусад, Чөлөөт нисэхийн үйл ажиллагаанд ашигладаг агаарын хөлөг	<ul style="list-style-type: none"> • Агаарын хөлгийн бүртгэлийн дугаар, эсхүл таних тэмдэг, хэрэв тухайн агаарын хөлгийг ИНД-47-гийн дагуу бүртгэх шаардлагагүй бол • Ниссэн цаг • Зорчигч тээвэрлэсэн нислэгийн тоо
Чөлөөт нисэхийн үйл ажиллагаанд ашигладаг шүхэр	<ul style="list-style-type: none"> • Шүхрийн таних тэмдэг • Тандем шүхрийн буултын тоо
Дээр зааснаас бусад, нислэгийн үйл ажиллагаанд ашигладаг Монгол Улсын бүртгэлтэй стандарт, эсхүл хязгаарлалтай категорийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй агаарын хөлөг	<ul style="list-style-type: none"> • Агаарын хөлгийн бүртгэлийн дугаар • Ниссэн цаг

Хүснэгт 2. Хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаанд ашигласан агаарын хөлгийн тайланг мэдээлэх хугацаа

Тайлан	Хамрах хугацаа	Эцсийн хугацаа
1-р улирал	01 сарын 01-ээс 03 сарын 31	05 сарын 01
2-р улирал	04 сарын 01-ээс 06 сарын 30	08 сарын 01
3-р улирал	07 сарын 01-ээс 09 сарын 30	11 сарын 01
4-р улирал	10 сарын 01-ээс 12 сарын 31	02 сарын 01

Хүснэгт 3. Хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаа эрхэлдэггүй агаарын хөлгийн тайланг мэдээлэх хугацаа

Тайлан	Хамрах хугацаа	Эцсийн хугацаа
Жилийн	01 сарын 01-ээс 12 сарын 31	02 сарын 01

12.152. ХАА-н нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн статистик мэдээ (шилжилт)

(a) ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь дараах мэдээллийг агуулсан тайланг Хүснэгт 2-т заасан хамрах хугацаа болон эцсийн хугацаанд Даргад хүргүүлнэ:

- (1) мэдээний хамрах хугацаа;
- (2) гэрчилгээ эзэмшигчийн нэр;
- (3) агаарын хөлгийн бүртгэлийн дугаар;
- (4) тайлангийн хугацаанд ачаалалтай хийсэн тээвэрлэлтийн тоо;
- (5) тайлангийн хугацаанд ашигласан бүх аэродромын байрлал;
- (6) ургамлын тэжээл, хөрсний бордоо, ургамлын тархалт, эсхүл хортон шавьж устгах зорилгоор ХАА-н химийн бэлдмэл, эсхүл бусад бодис цацах нислэгийн үйл ажиллагааны үед:
 - (i) тээвэрлэсэн ачааны төрөл;
 - (ii) тээвэрлэсэн ачааны нийт жин, эсхүл хэмжээ;
 - (iii) боловсруулсан нийт талбайн хэмжээ.

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу шаардсан статистик мэдээллийг Даргын хүлээн зөвшөөрөхүйц цахим, эсхүл бичгийн хэлбэрээр хүргүүлнэ.

12.153. Статистикийн тайлангийн нууцлал

(a) ИНЕГ, эсхүл ИНЕГ-ын ажилтан нь дараахаас бусад тохиолдолд, статистикийн тайланд тусгагдсан, агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийг таньж тогтоох мэдээллийг ИНЕГ-аас гадагш бусад этгээдэд дамжуулахгүй:

- (1) тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн зөвшөөрөлтэйгээр; эсхүл
- (2) Чикагогийн конвенцийн 67 дугаар зүйлийн дагуу; эсхүл
- (3) эрх зүйн баримт бичгээр шаардсаны дагуу.

(b) ИНЕГ нь олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаатай холбоотой статистикийн мэдээллийг ICAO-гийн Зөвлөлд гаргаж өгч болно.

- Part 19-өөс шилжүүлсэн.

ХАВСРАЛТ А. ЗААВАЛ МЭДЭЭЛЭХ ЗӨРЧЛҮҮДИЙН ЖАГСААЛТ

A-1. Агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа / Aircraft flight operations

- 1.1. Агаарын хөлгийн үйл ажиллагаа / Operation of the aircraft
- 1/ V - хурдны ойролцоо буюу түүнээс дээш хурданд аюултай, эсхүл аюулд хүргэж болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдол (зогсоогдсон хөөрөлт, сүүл цохих, хөдөлгүүр унтрах г.м);
- 2/ Шийдвэр гаргах өндрөөс нам өндөрт 2 дугаар тойрогт гарснаас болж аюултай, эсхүл аюулд учруулж болзошгүй нөхцөл байдал үүссэн;
- 3/ Гадны аливаа баримжаалах цэггүйгээр шийдвэр гаргах өндөр, эсхүл доошлох хамгийн бага үнэмлэхүй өндрөөс (MDA) доош орсон;
- 4/ Өөрийн байгаа байрлал, эсхүл ойр орчиндоо нисэж байгаа бусад агаарын хөлөгтэй байрлалын хувьд баримжаа алдах;
- 5/ Агаарын хөлгийн систем, эд ангийн ажиллагаа, аргачлалын алдаанаас үүдэлтэй агаарын замын тогтоогдсон шугам ба өндрөөс хазайсан зориудын бус хазайлт;
- 6/ Нисгэх багийн гишүүдийн хооронд (CRM), эсхүл бусад этгээдтэй /бүхээгийн гишүүд, НХУ, инженер/ харилцаа холбоо тасрах;
- 7/ Түлшний тэнцвэржилтийн хязгаарлалтыг давсан;
- 8/ SSR буюу тусгай үйлчилгээ хүссэн кодыг, эсхүл өндрийн хэрэглэлийг бүрүү тохируулсан;
- 9/ Навигацид ашиглагддаг, эсхүл үзүүлэлтүүдийг тооцоолоход ашигладаг тоног төхөөрөмжид бүрүү өгөгдөл оруулсан, бүрүү программчилсан, эсхүл бүрүү өгөгдөл ашигласан;
- 10/ Радио-телефоны мэдээг бүрүү хүлээж авсан, эсхүл бүрүү ойлгосон;
- 11/ Агаарын хөлөг нь өөр агаарын хөлөг, тээврийн хэрэгсэл, эсхүл газар дээр байгаа бусад объекттой мөргөлдөх;
- 12/ Нислэгийн аливаа үе шатанд агаарын хөлгийн зохих конфигураци (configuration)-д оруулах боломжгүй болох /хөл анги болон хөл ангийн хавхаг /landing gear door/, флапс, слатс, тогтворжуулагч /stabiliser/ г.м./;
- 13/ Сургалтын, эсхүл систем шалгах зорилгоор дуураймал гэмтэл үүсгэснээс болж аюултай, эсхүл аюулд хүргэж болзошгүй нөхцөл байдал үүссэн;
- 14/ Хэвийн бус чичиргээ;
- 15/ Конфигурацийн анхааруулга (configuration warning), хурдны уналт /stall warning/-ын анхааруулга, хэт хурдны анхааруулга (over-speed warning) зэрэг агаарын хөлгийн маневртай холбоотой анхааруулах систем ажиллах, үүнд

-Дүрэмд тусгах шаардлагагүй тайлбаруудыг дүрэмд оруулсан. Эдгээр 3Ц12-1-д тусгагдсан

доорх тохиолдлыг...
гэх мэт 7 нүүр үргэлжилсэн жагсаалт

**ХАВСРАЛТ Б. ЗААВАЛ МЭДЭЭЛЭХ НОЦТОЙ ЗӨРЧЛИЙН
ЖАГСААЛТ**

- 1/ Нислэгт байгаа агаарын хөлөг мөргөлдөж болзошгүй аюултай нөхцөл байдлаас гарах зорилгоор зайлшгүй үйлдэл хийхэд хүргэсэн аюултай ойртолт;
- 2/ Хэвийн удирдлага, хяналттай агаарын хөлөг аюулгүй зайнаас доош орж, газрын гадаргуутай мөргөлдөхөөс зайлсхийсэн нөхцөл;
- 3/ Хаалттай болон чөлөөлөгдөөгүй ХБЗ-аас болж агаарын хөлгийн хөөрөлтийг зогсоох;
- 4/ Хаалттай болон чөлөөлөгдөөгүй ХБЗ-ны саадаас, аюулгүй зайнаас бага зайд хөөрөлт үйлдэх;
- 5/ Хаалттай болон чөлөөлөгдөөгүй хөөрч, буух зурваст буух оролдлого хийх, буух;
- 6/ Гүйлтийн болон өндөр авалтын эхний шатанд агаарын хөлөг шаардлагатай үзүүлэлтүүдэд хүрэх боломжгүй/ чадамжгүй болох;
- 7/ Нислэгийн үед зорчигчийн бүхээг болон ачааны тасалгаанд гал гарах, утаа орж ирэх, хөдөлгүүрт гал гарах /гал унтраах хэрэгсэл ашиглан галыг унтраасан ч гэсэн/;
- 8/ Нисгэх баг хүчилтөрөгчийн төхөөрөмж яаралтай ашиглахад хүргэсэн нөхцөл;
- 9/ Осолд тооцогдохгүй, агаарын хөлгийн бүтцийн, эсхүл хөдөлгүүрийн эвдрэл;
- 10/ Агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаанд ноцтой нөлөөлж болох нэг болон түүнээс дээш систем ажилгүй болох;
- 11/ Нислэгийн үед нисгэх багийн гишүүд хөдөлмөрийн чадвараа алдах;
- 12/ Нисгэх багаас түлшний хэмжээний талаар онцгой нөхцөл зарласан /түлшний хэмжээ ноцтойгоор багассан, эсхүл түлш шилжүүлэх боломжгүй болсон, эсхүл хэрэглэх боломжтой /usable/ түлшийг дуустал хэрэглэсэн г.м./;
- 13/ Хөөрөлт, буултын үед зурвасыг давах, зурвасанд хүрэхгүй буух, зурвасны хажуу тийш гарах гэх мэт хөөрөлт, буултын үеийн зөрчил;
- 14/ Системийн татгалзал, цаг агаарын аюултай үзэгдэлтэй бүсэд орох, нислэгийн өгөгдөхүүний хязгаарлалтаас давах зэрэг агаарын хөлгийг жолоодоход хүндрэл учруулсан нөхцөл;
- 15/ Нислэгийн удирдлага болон навигацид зайлшгүй шаардлагатай нөөц системийн нэгээс дээш системийн

-Эдгээр нь тогтмол өөрчлөгддөг тул дүрэмд оруулах нь буруу шаардлагагүй. 3Ц12-1-д тусгагдсан.

	<p><u>татгалзал;</u> <u>16/ Агаарын хөлгөөс сэнсний алганы аливаа хэсэг салах /газартай шүргэлцэж салснаас бусад/ тохиолдол;</u> <u>17/ Агаарын хөлгийн нисгэгчийн бүхээгийн дэлгэц /Primary Flight Display (PFD) болон Primary Navigation Display (PND), мөн бусад бүрэлдэхүүн дэлгэцүүд болох Electronic Flight Instrument System display (EFIS), Engine Indication and Crew Alerting System (EICAS), Electronic Centralized Aircraft Monitor (ECAM) г.м/-үүдийн 50-иас</u> <u>дээш хувийн мэдээлэл бүрэн алдагдсан;</u> <u>18/ Хэрэглэлийн нислэгийн дүрэм /ХНД/-ийн нислэгийн төлөвлөгөөгөөр болон “А” ангиллын агаарын зайд нислэг үйлдэж байгаа агаарын хөлөг нэг болон түүнээс дээш агаарын хөлөгтэй мөргөлдөх бодит эрсдлээс зайлсхийхийн тулд Airborne Collision and Avoidance System (ACAS)-аас өгсөн зөвлөмжийг дагасан;</u> <u>19/ Нисдэг тэрэгний даах сэнсний, эсхүл сүүлний сэнсний алганы эвдрэл;</u> <u>20/ Гал, дэлбэрэлт, утаа, эсхүл хортой утаа /галыг унтраасны дараа гарч байгаа утааг оруулна/;</u> <u>21/ Аврах ажиллагаа /evacuation/ хийхэд хүргэсэн тохиолдол;</u> <u>22/ Битүүмжлэл алдагдсан;</u> <u>23/ Онцгой нөхцөл байдал зарлахад хүргэсэн тохиолдол /mayday, эсхүл panne/.</u></p>	<p>-3Ц12-1-д тусгагдсан.</p>
<p>Хавсралт А-Зөрчлийн анхны мэдээлэлд шаардлагатай мэдээлэл (а) Агаарын зайн зөрчил - 12.55(d)(1)-д заасан агаарын зайн зөрчлийн тухай мэдээлэлд дараах мэдээлэл багтсан байх шаардлагатай:</p> <ol style="list-style-type: none"> (1) зөрчлийн огноо, цаг; (2) үйл явдлын товч тайлбар; (3) агаарын хөлгийн үндэсний харъяалал, бүртгэл, дуудлага, нислэгийн дугаар болон маяг; (4) агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн нэр; (5) агаарын хөлгийн байршил, нислэгийн түвшин; (6) хөлгийн даргын нэр; (7) нислэгийн үе шат; (8) нислэгт үзүүлсэн нөлөө; (9) агаарын хөлөг үйл ажиллагаа гүйцэтгэж байсан нислэгийн дүрэм; (10) агаарын хөлгийн нисэн гарсан болон хүрэх цэг; (11) агаарын зайн байрлал, төрөл, ангилал болон оролцсон НХҮ-ний нэгж; (12) холбогдох нисгэгчийн өгсөн бусад хамааралтай 		<p>-Орхигдуулсан хавсралтыг нөхөж оруулсан</p>

мэдээлэл.

(b) **Гэмтлийн зөрчил** - 12.55(d)(2)-т заасан гэмтлийн зөрчлийн тухай мэдээлэлд дараах мэдээлэл багтсан байх шаардлагатай:

- (1) зөрчлийг илрүүлсэн огноо, цаг;
- (2) үйл явдлын товч тайлбар;
- (3) агаарын хөлгийн үндэсний харъяалал, бүртгэл болон маяг;
- (4) агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч болон өмчлөгчийн нэр;
- (5) зөрчил гарсан үед агаарын хөлөг, эд анги, эсхүл төхөөрөмжийн байсан байрлал;
- (6) нислэгийн үе шат;
- (7) нислэгт үзүүлсэн нөлөө;
- (8) агаарын хөлгийн нисэн гарсан болон хүрэх цэг;
- (9) агаарын хөлөг, эд анги, эсхүл төхөөрөмж үйлдвэрлэгчийн нэр, шаардлагатай тохиолдолд, эд ангийн дугаар, түүний модификацийн стандарт болон агаарын хөлөг дэх байрлал;
- (10) зөрчлийн тайлбар, түүний нөлөө болон бусад хамааралтай мэдээлэл;
- (11) мэдээлэл өгсөн этгээд, эсхүл байгууллага гэмтлийг шинжлэн шалгах ажиллагааг эхлүүлсэн бол, дуусгахаар төлөвлөсөн хугацаа;
- (12) зөрчлийг мэдээлсэн этгээдийн нэр, байгууллага болон холбоо барих мэдээллийн дэлгэрэнгүй.

(c) **Байгууламжийн доголдлын зөрчил** - 12.55(d)(3)-т заасан байгууламжийн доголдлын зөрчлийн тухай мэдээлэлд дараах мэдээлэл багтсан байх шаардлагатай:

- (1) зөрчлийн огноо, цаг;
- (2) үйл явдлын товч тайлбар;
- (3) агаарын хөлгийн үндэсний харъяалал, бүртгэл, дуудлага, нислэгийн дугаар болон маяг;
- (4) агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн нэр;
- (5) агаарын хөлгийн байршил нислэгийн түвшин;
- (6) аэродромын нэр, ашигласан ХБЗ;
- (7) хөлгийн даргын нэр;
- (8) нислэгийн үе шат;
- (9) нислэгт үзүүлсэн нөлөө;
- (10) холбогдох нисэхийн радио холбооны байгууламжийн үйлчилгээ үзүүлэгчийн нэр, төрөл, таних тэмдэг болон давтамж;
- (11) мэдээлэл өгсөн этгээд, эсхүл байгууллага зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг эхлүүлсэн бол, дуусгахаар төлөвлөсөн хугацаа;

-Орхигдуулсан хавсралтыг нөхөж оруулсан

(12) зөрчлийг мэдээлсэн этгээдийн нэр, байгууллага болон холбоо барих мэдээллийн дэлгэрэнгүй.

(d) **Агаарын хөлгийн зөрчил** - 12.55(d)(4)-т заасан агаарын хөлгийн зөрчлийн тухай мэдээлэлд дараах мэдээлэл багтсан байх шаардлагатай:

- (1) зөрчлийн огноо, цаг;
- (2) үйл явдлын товч тайлбар;
- (3) агаарын хөлгийн үндэсний харъяалал, бүртгэл, дуудлага, нислэгийн дугаар болон маяг;
- (4) агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч болон өмчлөгчийн нэр;
- (5) агаарын хөлгийн байршил нислэгийн түвшин;
- (6) нислэгийн үе шат;
- (7) хамааралтай бол, аэродромын нэр ашигласан ХБЗ;
- (8) нислэгт үзүүлсэн нөлөө;
- (9) хөлгийн даргын нэр;
- (10) гүйцэтгэж байсан үйл ажиллагааны төрөл;
- (11) агаарын хөлгийн бүхээгт байсан хүний тоо;
- (12) зөрчлийг мэдээлсэн этгээдийн нэр, байгууллага болон холбоо барих мэдээллийн дэлгэрэнгүй.

(e) **Аюулгүйн хамгаалалтын зөрчил** - 12.55(d)(5)-д заасан аюулгүйн хамгаалалтын зөрчлийн тухай мэдээлэлд дараах мэдээлэл багтсан байх шаардлагатай:

- (1) зөрчлийн огноо, цаг;
- (2) үйл явдлын товч тайлбар;
- (3) агаарын хөлгийн үндэсний харъяалал, бүртгэл, дуудлага, нислэгийн дугаар болон маяг;
- (4) агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч болон өмчлөгчийн нэр;
- (5) агаарын хөлгийн байршил болон нислэгийн түвшин, эсхүл зөрчил болсон газар;
- (6) хэрэв хамааралтай бол, аэродромын, эсхүл нисэхийн радио холбооны байгууламжийн нэр;
- (7) хөлгийн даргын нэр;
- (8) нислэгийн үе шат;
- (9) нислэгт үзүүлсэн нөлөө;
- (10) гүйцэтгэж байсан үйл ажиллагааны төрөл;
- (11) зөрчлийг мэдээлсэн этгээдийн нэр, байгууллага болон холбоо барих мэдээллийн дэлгэрэнгүй.

(f) **Түгээгдсэн мэдээллийн зөрчил** - 12.55(d)(6)-д заасан түгээгдсэн мэдээллийн зөрчлийн тухай мэдээлэлд дараах мэдээлэл багтсан байх шаардлагатай:

- (1) зөрчлийг илрүүлсэн огноо, цаг;
- (2) үйл явдлын товч тайлбар;

-Орхигдуулсан хавсралтыг нөхөж оруулсан

- (3) хэвлэл, газрын зураг, нислэгийн зураг, эсхүл бусад хэлбэрээр түгээгдсэн мэдээлэл, эсхүл нисэхийн өгөгдлийг таньж тогтоох дэлгэрэнгүй мэдээлэл;
- (4) зөрчилд хүргэсэн мэдээлэл, эсхүл нисэхийн өгөгдөлтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл;
- (5) зөрчлийг мэдээлсэн этгээдийн нэр, байгууллага болон холбоо барих мэдээллийн дэлгэрэнгүй.
- (g) Аэродромын зөрчил - 12.55(d)(7)-д заасан аэродромын зөрчлийн тухай мэдээлэлд дараах мэдээлэл багтсан байх шаардлагатай:
- (1) зөрчлийн огноо, цаг;
- (2) үйл явдлын товч тайлбар;
- (3) аэродромын нэр;
- (4) мэдээлсэн гэмтэл, эсхүл саадын тодорхойлолт болон байрлал;
- (5) зөрчлийг мэдээлсэн этгээдийн нэр, байгууллага болон холбоо барих мэдээллийн дэлгэрэнгүй.
- (h) Ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчил - 12.55(d)(8)-д заасан ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчлийн тухай мэдээлэлд дараах мэдээлэл багтсан байх шаардлагатай:
- (1) зөрчлийн огноо, цаг;
- (2) зөрчлийн шинж байдлын товч тайлбар;
- (3) хэрэв мэдэгдэж байгаа бол, зөрчил гарсан байж болох газрын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (4) зөрчлийг мэдээлсэн этгээдийн нэр, байгууллага болон холбоо барих мэдээллийн дэлгэрэнгүй.
- (i) Аюултай бараа, шувуутай холбоотой, эсхүл бусад зөрчил - 12.55(d)(9)-д заасан аюултай бараа, шувуутай холбоотой, эсхүл бусад зөрчлийн тухай мэдээлэлд дараах мэдээлэл багтсан байх шаардлагатай:
- (1) зөрчлийн огноо, цаг;
- (2) үйл явдлын товч тайлбар;
- (3) зөрчлийг мэдээлсэн этгээдийн нэр, байгууллага болон холбоо барих мэдээллийн дэлгэрэнгүй.

Дүрмийн боловсруулалтын хэлтэс